Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ой мандтугай!

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн.

ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, АДХ Гүйцэтгэх захиргааны сонин

21 дэхь жилдээ № 83 (1772) | 1968 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 7 | ПҮРЭВ

# ИХ ОКТЯБРЬ

Октябрийн социалист их хувьсгал ялан мандсанаас хойш 51 жил болж байна. Хүн төрөлхтний түүхэнд шинэ эриннийг нээсэн Октябрийн их хувьсгалын жилүүдэд зөвлөлтийн баатарлаг ард түмэн өөрийн орныг хүнд үйлдвэржүүлэн хөдөө аж ахуйгаа социалист ёсоор өөрчлөн соёлын хувьсгал хийснээр социализмыг бүрэн төгс ялуулан коммунизмын байгууламжандаа асар их амжилтыг олж байна. Аугаа их Октябрийн үзэл санаа, үйл хэрэг тал бүрийн түүхэн сорилтыг даван туулж, ялагдашгүй хүч чадлаа дэлхий дахины өмнө яруу тод харуулж чадсанаар үй олон хүний санаа бодолд их Октябрийн үзэл санаа хоногшин шингэж, орчин үеийн хамгийн хүчирхэг хүчин болов.

Ингэснээрээ хүн төрөлхтний түүхэн хөгжлийн үндсэн хандлага, түүний агуулга, чиглэл, гол онцлогийг одоо үед дэлхийн социалист систем, дэвшилт хүчнүүд тодорхойлж байна.

Эх орондоо коммунизм байгуулж байгаа Зөвлөлтийн ард түмэн, коммунист намынхаа 23 дугаар их хурлын шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэн коммунизм байгуулах их үйлсдээ шинэ шинэ амжилт олсоор байна.

1967 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 7,3 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөж 10 хувь буюу бараг 3 хувиар давуулсан байна.

1965—67 онуудад ажилчдын бодит цалин 7 хувь, хөдөөгийн хүн амын бодит орлого 20 хувиар өсчээ. 1968 онд ЗХУ—ын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 8 хувиар нэмэгдсэн байна.

Энэ оны байдлаар ЗХУ жилд 650 миллиард киловат цагийн цахилгаан эрчим хүч боловсруулан гаргаж, 300 сая гаруй тонн нефть, 600 сая тонн чулуун нүүрс, 107 сая тонн болд үйлдвэрлэжээ.

Коммунизмын эх орон ЗХУ асар хурдан хөгжлийнхөө үр дүнд сансарт аялан жуулчлах талаар хүн төрөлхтний түүхэнд гарамгай гавъяа байгуулсан билээ.

Сансрыг эзэмших талаар ЗХУ-ын олсон бас нэг том амжилт бол энэ оны 9 дүгээр сард Зөвлөлтийн автомат станц «Зонд-5» дэлхий-сар-дэлхийн замд амжилттай аялан эх дэлхийд тооцоолсон районд зөөлнөөр буулгасан болон ЗХУ—ын иргэн, баатар Георгий Береговой «Союз—3» огторгуйн хөлгөөр амжилттай аялсан явдал юм. Дэлхийн хөдөлмөрчдийн суут багш В. И. Ленин, монголын хувьсгалын гарамгай удирдагч Д. Сүхбаатар нарын үндэслэн байгуулсан Монгол—Зөвлөлтийн ард түмний эвдэршгүй найрамдал нь их Октябрийн тунхагласан олон улсын харилцааны зарчим, бие биеэ хүндэтгэж ах дүү ёсоор харилцан туслах жинхэнэ тэгш эрхийн зарчим дээр тулгуурласан билээ.

Ийм учраас монголын ард түмэн бид энэхүү найрамдлаа хайрлан хамгаалж, бахархаж байдаг.

Манай ард түмэн Октябрийн социалист хувьсгалын ойг өөрийн үндэсний их баяр, эрх чөлөө зол жаргалынхаа замыг олсны баяр гэж хүндэтгэн тэмдэглэж байдаг юм. Октябрийн хувьсгалын өлгий ЗХУ манай орны хөгжил цэцэглэлтэд зүйл бүрийн өгөөмөр тусламж үзүүлж ирсэн ба үзүүлсээр байна.

Одоо манай аймгийн Заамар, Баяндэлгэр сумд ЗХУ-ын их тусламжаар тохижин тэнд орчин үеийн хотыг сүндэрлүүлэн босгож шинэ амьдрал цогцлуулсан гайхамшигт сайхан барилга байгууламжаа Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ой, Монгол—Зөвлөлтийн ард түмний уламжлалт найрамдлын сараар тохиолдуулан бидэнд хүлээлгэн өгч байгаа нь бас нэг баярт үйл явдал болж байна.

Манай хөдөлмөрчид МАХН—ынхаа 15 дугаар их хурлын түүхт шийдвэр, МАХН—ын программыг амьдралд хэрэгжүүлэн, улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 4 дүгээр таван жилийн төлөвлөгөөний гурав дахь жил 1968 оны төлөвлөгөөг амжилттай биелүүлж байна. Тус аймгийн бүтээлч хөдөлмөрчид Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ойг угтаж социалист уралдаан, өндөр бүтээлийн ажлыг үйлдвэрийн салбар бүрт өрнүүлэн ажилласны дүнд аймгийн нийт үйлдвэрүүд 3 дугаар улиралд 157,5 мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6,1 хувиар ахижээ.

Энэ нь манай аймгийн хөдөлмөрчдийн бүтээлч хөдөлмөрийн үр дүн мөн.

Одоо манай хөдөлмөрчдийн өмнө ХАА-н материаллаг баазыг бэхжүүлж түүний үр ашгийг нэмэгдүүлэх, малыг онд сайн оруулах бэлтгэл ажлыг бүрэн хангахын зэрэгцээ үйлдвэрлэлийн төлөвлөгөөг нэр төрөл, тоо чанарын хувьд давуулан биелүүлэх эрхэм зорилтууд зогсож байна.

Иймээс дээрх зорилтыг биелүүлэхэд бүхий л хүчээ дайчлан ажиллацгаая.




## Баярын хурал

Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ойд зориулсан тус аймгийн нам, улс, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн баярын хурал өчигдөр орой аймгийн Соёлын ордонд болов. Баярын хурлыг аймгийн Намын Хорооны нарийн бичгийн дарга Д. Дамбажамц нээж, «Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ойн» тухай илтгэлийг аймгийн Намын Хорооны Товчооны гишүүн, Намын Хянан Шалгах комиссын дарга Р. Чимэдцэрэн тавив.

Хурлын дараа сайн дурын уран сайханчдын концерт тоглов.

**Манай сурвалжлагч**

## ИХ БАЯРЫН БОСГОН ДЭЭР

Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ойг аймгийн төвийн үйлдвэрүүд ажлын өрнүүн амжилтаар угтав.

Тус аймгийн төвийн Артель их баярыг угтаж 1968 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний 80 хувийг биелүүлээд байгаагийн дотор хивс, оёдол, үйлчилгээ, савхин гутлын тасгууд 10 дугаар сарын 1-ид жилийнхээ төлөвлөгөөний 98—119,5 хувийг биелүүлсэн сайхан амжилтын дүнтэй байна.

Мөн хивсчин Маанжий, Баасанжав, оёдолчин Рэнцэнханд, Даваасүрэн, гуталчин Дангаа, Р.Ичинхорлоо, Мөнхөө, мужаан Мижид нарын зэрэг олон ажилчид 10 дугаар сарын төлөвлөгөөгөө 150—200 хувиар биелүүлжээ.

*Аймгийн Харилцаа холбооныхон ч багагүй амжилтаар баяраа угтжээ.

Шуудан, радио телефон, суваг цахилгааны тасгууд 10 дугаар сарын төлөвлөгөөгөө 100—136,2 хувиар биелүүлсний дотор монтёр Дагва, ялгагч Цэрэнханд, касс Пүрэвжаргал нар төлөвлөгөөгөө 101,9—127,5 хувиар биелүүлжээ.

*Мөн аймгийн Хүнсний комбинатын Хуяг мастертай архин цехийн хамт олон 1968 оны төлөвлөгөөг 11 дүгээр сарын 4-ний байдлаар 103 хувиар биелүүлэв.

**Ж. Төмөрсүх**

